



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93

Э-мэйл: khuvs gul@audit.gov.mn

Вэбсайт: www.audit.mn

2022.08.14 № 01/603
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ДАВААЦЭРЭНГИЙН ГАН-ЭРДЭНЭ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Даваацэрэнгийн Ган-Эрдэнийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Даваацэрэнгийн Ган-Эрдэнийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050” болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Даваацэрэнгийн Ган-Эрдэнийн сонгуулийн мөрийн хөтөлбөр / 3 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд
Хавсралт 3 хуудастай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




О.ГАНБОЛД

ХЯНАСАН:
АХЛАХ АУДИТОР



Э.БАТ-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:
АУДИТОР



З.ДАВААДОРЖ

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ДАВААЦЭРЭНГИЙН ГАН-ЭРДЭНИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020.07.22.

Мөрөн хот.

Нэр дэвшигч миний бие сонгуулийн мөрийн хөтөлбөрийг МУ-ын УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, мөн 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2015 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр” зэрэг баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд, түүнд тулгуурлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон мөн хуулийн 39 дугаар зүйлд нийцүүлэн боловсруулав.


Мөрийн хөтөлбөрийн үндсэн агуулга, зорилго:Хөвсгөл аймагт хууль ёсоор оршин суугаа иргэн бүрийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгож, хөдөлмөр эрхлэн цалин хөлс авах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээнд төрөөс үнэ төлбөргүй хамрагдах, төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх зэрэг Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөний баталгааг бодитоор бий болгож, иргэн бүрт хүртээмжтэй төрийн үйлчилгээ, төрийн албаны сахилга батыг төлөвшүүлж, хүнд сурталыг арилгах, эрхээ эдэлж, үүргээ хүлээж, орон нутагтаа сайхан амьдрах иргэний эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг төрөөс бүрдүүлэхэд чиглэн ажиллана.

1. Орлоготой иргэн.

МУ-ын хэмжээнд ажилгүйдлын түвшингөөр Хөвсгөл аймаг тэргүүлж байна./

1.1. “COVID-19 цар тахал”-ын дэгдэлттэй холбоотойгоор дотоодын аялал жуулчлал нэмэгдэж, түүнээс олох орлого өндөр өсөлт үзүүлж байна.

Иймд Алунгоо хатны хөшөө цогцолбор, Цэгэрийн соёмбо, урианхай



A handwritten signature in black ink, consisting of a stylized, cursive script.

A handwritten signature in black ink, followed by the number "3.25" written in a similar cursive style.

ёс заншил гэх мэт байгалийн дурсгалт газрууд, аялал жуулчлалын цогцолбор газруудыг түшиглэн орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого боловсруулан, орон нутгийн аялал жуулчлал болон эдийн засгийг нэмэгдүүлэх бодлого санаачлан хэрэгжүүлнэ.

- 1.2. Иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг ажлын байртай шууд холбон тогтвортой ажил, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох бодлого баримталж ажиллана.
- 1.3. Орон нутгийн бренд бүтээгдэхүүн, бараа материалыг үйлдвэрлэж, ажлын байр нэмэгдүүлж буй жижиг дунд үйлдвэрлэл болон өрхийн бичил бизнесийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.4. Ажлын байр нэмэгдүүлсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олгосон аж ахуйн нэгж болон ажлын байрандаа олон жил тогтвор суурьшилтай ажилласан иргэдийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр санаачилна.
- 1.5. Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтална.
- 1.6. Усалгаатай газар тариаланг сэргээж дэмжих бодлого баримтална. Ажлын байр нэмэгдэж, мөн хүнсний бүтээгдэхүүнийг орон нутагтаа үйлдвэрлэх, төмс, хүнсний ногооны, дотоодын хэрэгцээг хангах боломж бүрдэнэ.
- 1.7. Жимс, жимсгэнэ эмийн ургамал зэрэг дээр нэмүү өртөг шингээж, иргэдийн гар дээрээс авах үнийн дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн санаачлага гарган хэрэгжүүлнэ.
- 1.8. Орон нутгийн онцлогт тохирсон бодлогын санаачлагаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2. Эрүүл иргэн.

- 2.1. Сум орон нутагт эрүүл мэндийн үзлэг оношилгоог тогтмол, хүртээмжтэй зохион байгуулахад анхаарч ажиллана.
- 2.2. Иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулж, төрийн үйлчилгээний хамтын ажиллагаа, харилцан



17144193
062 90706

3. 8/2

10000002


хяналтыг өргөжүүлэхэд анхаарч ажиллана.

- 2.3. Хөнгөлөлттэй олгогддог эм тариаг нэмэгдүүлэх, амжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэд эмнэлгийн тусламж үйлчилгээнд саадгүй хамрагдах боломжийг бүрдүүлэх санаачлага гаргаж, хэрэгжүүлнэ.
- 2.4. Орон нутагт сайн дурын иргэдэд анхны тусламж үйлчилгээ болон эм зүйн түргэвчилсэн сургалт зохион байгуулж, өрх айл бүрд эмнэлгийн анхны тусламж үзээлэх чадавхийг бүрдүүлэхэд чиглэн ажиллана.

3. Хариуцлагатай иргэн:

- 3.1. Төсөв, мөнгө, боловсон хүчний болон эд хөрөнгөний эрх мэдлийг бодитой шилжүүлэх замаар нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даасан байдлыг хангана.
- 3.2. Нийгмийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хувь хүн, гэр бүлийн хөгжлийг бүрэн дэмжсэн байх зарчимд тулгуурласан бодлогоор хэрэгжүүлнэ.
- 3.3. Төрийн үйлчилгээнд иргэдийн хяналт, хамтын ажиллагаа, уялдаа холбоог бий болгох, хардлага, хүнд суртлыг арилгахад чиглэсэн санаачлага бий болгоно.

БОЛОВСРУУЛСАН:



Д.ГАН-ЭРДЭНЭ

/БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИ/

Хаяг: Хөвсгөл аймаг, Чандмань-Өндөр сум 4-р


баг Хөвөн хороолол 203 тоот

Регистерийн дугаар

РТ87052071

Утас: 88095958

Цахим хаяг: ganerdene052071@gmail.com



0000002
0000003